



ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН ХҮҮХДЭД ҮЗҮҮЛЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН БОЛОН БУСАД ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ, ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ГОМДОЛ МЭДЭЭЛЭЛ, ТҮҮНИЙ ШИЙДВЭРЛЭЛТЭД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

МОНИТОРИНГИЙН ТУХАЙ

Нээлттэй Нийгэм Форум нь хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн болон бусад тусламж үйлчилгээ, хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, шалган шийдвэрлэх үйл ажиллагаанд мониторинг хийх тэтгэлгийг Эрх зүйн соёл ТББ-д олгосон билээ. Мониторингийн явцад ХСИС-ийн докторант, цагдаагийн бэлтгэл дэд хурандаа С.Дина мэргэжил, арга зүйн удирдамжаар хангаж ажиллалаа. Тус мониторингийг 2019 оны 4-р сараас 12-р сарыг дуустал хугацаанд хэрэгжүүлэв.

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ГБХЗХГ	Гэр бүл, Хүүхэд, Залуучуудын хөгжлийн газар
ЭХЭМҮТ	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв
НЦГ	Нийслэлийн цагдаагийн газар
ЭХТА	Эрүүгийн хуулийн тусгай анги
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
МСҮТ	Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв
БСШУСЯ	Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын яам
ХЗДХС	Хууль зүй дотоод хэргийн сайд
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ХНХС	Хөдөлмөр нийгэм хамгааллын сайд
ЭМЯ	Эрүүл мэндийн яам

ҮНДЭСЛЭЛ

Монгол Улс Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Хүүхдийн эрхийн тухай конвенц, Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 182 дугаар конвенц, Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг хүүхдийн эрхийн тухай конвенцод оруулах нэмэлт протоколд тус тус нэгдэн орж, соёрхон баталж, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө үүрэг хүлээсэн билээ. Хүүхдийн эрхийг хангах, хамгаалах зорилгоор Хүүхдийн эрхийг хамгаалах тухай, Гэр бүлийн тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй

тэмцэх тухай, Гэмт хэрэг хянан шийдвэрлэх тухай, Гэрч хохирогчийг хамгаалах тухай болон Эрүүгийн хуулиуд тус тус баталж, хүүхэд хамгаалах цогц эрх зүйн орчинтой улс болсон.

Хэдийгээр эрх зүйн орчин бүрдсэн ч хүүхдийн эсрэг хүчирхийлэл ихэвчлэн гэр бүл, сургууль, цэцэрлэгийн хүрээнд нууц далд хэлбэрээр үйлдэгдэж, тэр бүр илрэхгүй өнгөрсөөр байна. Тиймээс энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэх ажиллагаанд хөндлөнгийн үнэлгээ хийх нь чухал ач холбогдолтой.

ЗОРИЛГО

Хүүхдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг эмнэлгийн байгууллага хүчирхийлэлд өртсөн хүүхдийг илрүүлэн гэмт хэргийн тухай гомдол мэдээлэл гаргах явц, энэ талаарх

хууль тогтоомжийн хэрэгжилтэд үнэлгээ өгөх, гаргасан гомдол, мэдээллийн шийдвэрлэлтэд дүн шинжилгээ хийж, дүгнэлт, зөвлөмж гаргахыг зорилоо.

АРГА ЗҮЙ

Баримт бичигт дүн шинжилгээ хийх, зорилтот бүлгүүдээс анкетын болон ярилцлагын аргаар мэдээлэл цуглуулах арга зүйг ашигласан болно. Мэдээллийг legalinfo.mn, Эрүүл мэндийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Хөдөлмөр, нийгэм хамгааллын яам, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв

(ЭХЭМҮТ), Нийслэлийн цагдаагийн газрын Мэдээлэл дүн шинжилгээний алба, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Хүүхдийн тусламжийн утас 108 үйлчилгээний төв зэрэг газруудаас тоон болон асуулга, анкетын аргаар цуглууллаа.

МОНИТОРИНГИЙН ДҮН

Нэг. ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ХҮҮХДИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙГ ИЛРҮҮЛЭХ, МЭДЭЭЛЭХ ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн хүүхдийн эмнэлэг нь улсын хэмжээнд хүүхдэд дагнан үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн гол төв юм. Энэ ч утгаараа эрүүл мэндийн тусламж үйлчилгээ шаардлагатай харьяа дүүргээс болон бусад эмнэлгээс ирүүлсэн хүүхдэд шаардлагатай үзлэг, оношилгоо, эмчилгээг хийдэг байна. Тус эмнэлэгт өвдөн эмчлүүлж байгаа хүүхдээс гадна хүчирхийлэлд өртсөн, амиа хорлохыг завдсан, хаягдсан гэх мэтээр эрүүл мэндийн хувьд тулгамдсан асуудалтай хүүхдүүд үйлчлүүлдэг. Хүчирхийлэлд өртсөн хүүхэд үйлчилгээ авахдаа амбулатори, яаралтай тусламж, өсвөр үеийн клиник (ӨҮК гэх)-ийн аль нэгээр үйлчлүүлдэг хэдий ч хүчирхийлэлд өртсөн хүүхдүүдийг ихэвчлэн ӨҮК-т төвлөрүүлэн голлох үйлчилгээг үзүүлж байна.

Өсвөр үеийн клиникийг ЭХЭМҮТ-ийн эмнэлгийн тусламж үйлчилгээг өргөжүүлэн

хөгжүүлэх зорилтын хүрээнд 2014 оны 2 дугаар сарын 12-ны өдөр ЭХЭМҮТ-ийн захирлын 65 тоот тушаалаар байгуулсан бөгөөд тус төвөөр хүчирхийлэлд өртсөн 0-24 насны тэр дундаа бэлгийн хүчирхийлэлд өртсөн охид ихээр үйлчлүүлдэг ажээ. Тус төв нь өсвөр үеийнхний эрүүл мэндийг дэмжих, ээлтэй тусламж үйлчилгээ үзүүлэх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, тэдэнд эрсдэлээс хамгаалах ур чадварыг эзэмшүүлэх үндсэн зорилготой байгуулагдсан.

Тус эмнэлэгт 2019 оны 7 сард “Хүчирхийлэлд өртсөн болон эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд ба эмэгтэйчүүдэд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх журам”, “ЭХЭМҮТ-өөр үйлчлүүлж буй хүчирхийлэлд өртсөн болон эрсдэлтэй нөхцөлд байгаа хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн нийгмийн ажилтны үйлчилгээний журам”, “Амиа хорлох

оролдлого хийж ЭХЭМҮТ-д хүргэгдэн ирсэн өсвөр насны хүүхдэд үзүүлэх сэтгэл зүйн тусламж үйлчилгээний удирдамж"-ыг батлан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Тус журмуудтай танилцахад хүчирхийлэлд өртсөн хүүхэд, эмэгтэйчүүд ирсэн тохиолдолд ямар журмаар эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх талаас нь сайн журамласан боловч хүчирхийлэлд өртсөнийг хэрхэн яаж илрүүлэх талаарх заавар, арга аргачлал хангалттай хэмжээнд журамлагдаагүй байна гэж үзэхээр байна.

ЭХЭМҮТ-ийн Хүлээн авах яаралтай тусламжийн тасаг, амбулаторийн тасгийн эмч нар хүүхдэд эрүүл мэндийн үзлэг хийхдээ хүчирхийллийн улмаас эрүүл мэндээрээ хохирсон өвчтөнийг илрүүлж, холбогдох хуулийн байгууллагад мэдээлэх, шаардлагатай эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлж ажиллахыг чухалчилдаг байна. Хүүхдүүдийн хувьд эмнэлгийн тусламж үйлчилгээ авч байхдаа хүчирхийлэлд өртсөн нь илрэх тохиолдол цөөнгүй гардаг бөгөөд эмч, эмнэлгийн байгууллагаас дараах үе шаттай арга хэмжээ авдаг.

- Эмчийн үзлэгийн явцад бэлгийн болон сэтгэл зүйн, бие махбодын хүчирхийлэлд өртсөн байж болзошгүй тохиолдолд хүүхдийг асран хамгаалагчаас тусгаарлан үзлэг хийхээс гадна асуумж авдаг байна. Бие махбодын үзлэг, асуумжийн үр дүнд хүүхэд хүчирхийлэлд өртсөн байж болзошгүй байвал хүүхдийг асран хамгаалагчаас тусгаарлаж, цагдаагийн байгууллага эсхүл Хүүхэд гэр бүл, залуучуудын хөгжлийн газрын дэргэдэх Хүүхдийн тусламжийн утас 108 үйлчилгээний төвд мэдээлэл өгдөг байна.
- Мөн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд эрүүл

мэндийн үйлчилгээ үзүүлэхийн зэрэгцээ хүүхдийг тайвшруулах, мэдээлэл авах, зөвлөгөө өгөх зорилгоор сэтгэл зүйн тусламж үзүүлдэг ажээ.

- Эмнэлгийн нийгмийн ажилтан хүүхдийн эрхийг хамгаалах талаар холбогдох байгууллагуудтай уулзаж, эцэг эх, асран хамгаалах байгууллагад холбон зуучилдаг.
- Хүчирхийлэлд өртсөн хүүхэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авч өсвөр үеийн клиникт хамрагдах ба энд эрүүл мэндийн болон сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлдэг.
- Мөн тус эмнэлэгт хүчирхийлэлд өртсөн нь илэрч эмнэлгийн шаардлагатай тусламж үйлчилгээнд хамруулахаар бусад байгууллагаар дамжин (цагдаа, хүүхдийн эрхийн байгууллага, бусад эмнэлэг гэх мэт) ирсэн хүүхдүүд мөн үйлчилгээ авдаг.

ӨҮК-т эмч, сувилагч тус бүр нэг ажилладаг бөгөөд хүүхэд, өсвөр насныхан тэдний эцэг эх, асран хамгаалагчдад эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэхдээ ЭХЭМҮТ-ийн сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, нийгмийн эрүүл мэндийн ажилтантай хамтран ажилладаг байна. Ачаалал нь сүүлийн жилүүдэд улам бүр нэмэгдэж байгаа ба сүүлийн 3 жилийн байдлаар тус клиникээр 9000 гаруй хүүхэд үйлчлүүлжээ. Тус төвд тулгараад буй асуудал нь эмч, ажилтны ажлын ачаалал, үйлчилгээний зардал, мөн хүүхдүүдийн эмчилгээ тасрах зэрэг юм.

Тус эмнэлэгт хандсан хүчирхийлэлд өртсөн хүүхэд, өсвөр насныхны 79.7 хувь нь бэлгийн хүчирхийлэлд, 20.3 хувь нь үл хайхрах, бие махбодын, сэтгэл санааны болон гэр бүлийн хүчирхийлэлд өртжээ. Тэдний 27 хувь нь 10 хүртэлх, 46 хувь нь 10-16, 24.3 хувь нь 16-18, 2.7 хувь 18 ба түүнээс дээш насныхан байна.

Хүснэгт 1. Өсвөр үеийн клиникээр үйлчлүүлсэн үйлчлүүлэгчдийн тоо
(ЭХЭМҮТ-ийн Өсвөр үеийн клиникийн 2018 оны үйл ажиллагааны тайлангаас)

Он	Үйлчлүүлэгчийн тоо	Насны бүлэг			Хүйс	
		0-9	10-18	19-24	Эр	Эм
2014 (11,12)	193	12	177	4	3	190
2015	3094	621	2473	-	18	3076
2016	2650	470	2180	-	11	2639
2017	3135	204	2887	44	403	2732
2018 (эхний 10 сар)	2327	321	1995	11	54	2273

Хүснэгт 2. Хүчирхийлэлд өртөж эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан хүүхэд, өсвөр насныхны тоо, нас, хүчирхийллийн хэлбэр, бэлгийн хүчирхийлэлд өртөж жирэмсэн болсон охидын тоо

№	Үйлчилгээний үзүүлэлтүүд	2014				2018	БҮГД
		11, 12-р сар	2015	2016	2017	эхний 10 сар	
1	Хүүхдийн эсрэг хүчирхийлэлд өртсөн өгүүлэмжтэй эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан хүүхэд, өсвөр насныхны тоо	9	44	41	58	64	216
2	Бэлгийн хүчирхийлэл	8 88.9%	42 95%	39 95%	52 89.7%	50 эм +1 эр 79.7%	192 (88.9%)
	Үүнээс (тоо, хувь)	1 11.1%	2 5%	2 5%	6 10.3%	11 эм +2 эр 20.3%	24 (11.1%)
3	10 нас хүртэл	-	8 18.1%	11 26.8%	8 13.8%	17 27%	44 (20.4%)
	10-16	7 77.7%	21 47.7%	18 46.9%	37 63.8%	35 46%	118 (54.6%)
	16-18	2 22.3%	15 34.2%	12 29.3%	10 17.2%	11 24.3%	50 (23.1%)
	18 ба түүнээс дээш	-	-	-	3 5.2%	1 2.7%	4 (1.9%)
4	Бэлгийн хүчирхийлэлд өртөж жирэмсэн болсон охид	3	9	9	19	15	55
	Хүчирхийлэлд өртөж үйлчлүүлсэн нийт хүүхдийн дотор эзлэх хувь	33.3%	20.4%	21.9%	32.7%	23.4%	24%
5	Жирэмсэн хандсан охидын дотор эзлэх хувь	27.3%	11.5%	11.3%	25.7%	20.8%	16.5%
	Бэлгийн хүчирхийлэлд өртөж жирэмслэн, хүүхэд төрүүлсэн охидын тоо (өсвөр насны ээж)	-	1	-	-	1	

Бэлгийн хүчирхийлэлд өртсөн охидын 28,6 хувь буюу 55 охин жирэмсэн болсон бөгөөд жирэмслэлтээ шийдвэрлэхээр ӨҮК-т ханджээ. Бэлгийн хүчирхийллийн улмаас жирэмсэн болсон охидын 36.3 хувь нь 13-15, 63.7 хувь нь 15-18 хүртэл насныхан байна. Бэлгийн хүчирхийллийн улмаас жирэмсэн болсон охидын 13.3 хувь нь жирэмсний 12 долоо хоног хүртэлх хугацаанд, 60 хувь нь

13-22 долоо хоногтойд, 26.7 хувь нь 23 ба түүнээс дээш долоо хоногийн хугацаанд буюу үр хөндөлт хийх боломжгүй хугацаанд ӨҮК-т ханджээ. Тэдгээр охидын 13.3 хувь нь жирэмсний эрт хугацаанд үр хөндүүлж, 60 хувь нь жирэмснээ хожуу хугацаанд таслуулсан ба 20 хувь нь жирэмснээ үргэлжлүүлж хяналтад орсон байна. Дутуу төрсөн нэг тохиолдол гарчээ.

Хүснэгт 3. Хүчирхийлэлд өртсөн үйлчлүүлэгч ЭХЭМҮТ-ийн ӨҮК-т хандсан мэдээлэл
(хаанаас илгээсэн, өөрсдөө ирсэн эсэх)

№	Хэрхэн ирсэн/хаанаас илгээсэн	Тоо	Хүчирхийлэлд өртсөн өгүүлэмжтэй нийт үйлчлүүлэгчид эзлэх хувь
1	Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний төвийн хамгаалах байр	7	10.9
2	Хүчирхийллийн эсрэг үндэсний төв	8	12.5
3	Цагдаагийн хэлтэс	7	10.9
4	Дүүргийн эрүүл мэндийн төв	4	6.2
5	ЭХЭМҮТ-ийн ХЭ-ийн тасаг	5	7.8
6	Хувийн эмнэлэг	2	3.1
7	Сум, өрхийн эмнэлэг	2	3.1
8	Аймгийн нэгдсэн эмнэлэг	1	1.6

9	Хүүхэд залуучуудын сургалт хүмүүжлийн тусгай цогцолбор	1	1.6
10	"Цэцэглэх ирээдүй" ТББ	1	1.6
11	"Ид шидийн орон" ТББ	8	12.5
12	"Хөөрхөн зүрхнүүдийн аян" ТББ	1	1.6
13	"Монголын хүүхдийн сан" ТББ-ын хамгаалах байр	1	1.6
14	Өөрсдөө	16	25
	Нийт	64	100

Хүснэгт 4. ЭХЭМҮТ-өөс Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвд ирсэн дуудлагын тоон мэдээ (ГБХЗХГ-аас ирүүлсэн тоо баримт)

№	Дуудлагын ангилал	2018 он	2019 он	Бүгд
1	Бие махбодын хүчирхийлэл	8	7	15
2	Үл хайхрах хүчирхийлэл	1	8	9
3	Бэлгийн хүчирхийлэл	15	17	32
4	Сэтгэл санааны хүчирхийлэл	2	0	2
5	Амиа хорлох	1	4	5
6	Алга болсон	0	2	2
7	Хараа хяналтгүй	1	3	4
8	Хорт зуршил	3	2	5
9	Яаралтай	5	0	5
10	Нас барсан	2	2	4
11	Санал хүсэлт	1	0	1
	Бүгд	39	45	84

Хүүхэд хүчирхийлэлд өртсөн байна гэж эмч үзвэл гэмт хэргийн тухай мэдээллийг нэн даруй харьяа дүүргийн цагдаагийн хэлтэс, цагдаагийн 102 утсаар болон хүүхдийн тусламжийн утас 108 руу ярьж мэдээлдэг байна. Гэвч эмчийн анхны үзлэгээр хүчирхийлэлд өртсөн нь мэдэгдэхгүй өнгөрөх тохиолдлууд гардаг. Энэ нь тухайн хүүхдийн асран хамгаалагч болон хүүхэд өөрөө гэмтэл бэртлийн талаар худал мэдээлэх, хэсэг газрын зовуурь нь хүчирхийлэлд өртсөн гэхээр шинжгүй байх болон эмч нарын ажлын ачаалал их, хүүхэд бүрийг хүчирхийлэлд өртсөн байх гэсэн сэдэл төрдөггүй, тэрийг шалгах арга аргачлал тодорхой бус байдгаас болдог байна.

Гэр бүлийн тухай хуулийн 15.1.14-т гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн, өртөж болзошгүй хүнийг илрүүлэх, яаралтай болон анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх, эмнэлгийн мэргэжилтний ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт зохион байгуулах үүрэг нь эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын үүрэг бөгөөд энэ үүргийн хэрэгжилтийг сайжруулж эмч эмнэлгийн ажилтнуудыг сургалтад хүртээмжтэй хамруулах талаар анхаарах шаардлагатай байна.

Шигтгээ 1. ЭХЭМҮТ-ийн Яаралтай түргэн тусламжийн тасгийн эмч

Цагдаагийн байгууллагаас холбогдож хүүхдийн мэдээллийг асуухдаа энэ хүүхэд өмнө нь танай эмнэлэгт үзлэг, шинжилгээнд орж байсан байх тул уг хүүхдийн эмчилгээний түүхийг ирүүлнэ үү гэж холбогдох тохиолдол байдаг. Бид үзлэг хийлгэхээр ирсэн хүүхдээс асуумж авсны үндсэн дээр шаардлагатай гэж үзвэл бүтэн биеийн нүцгэн үзлэг хийдэг. Тиймээс асуумжаар болон хэсэг газрын үзлэг хийх явцад хүчирхийлэлд өртөж байсан эсэх нь илрэхгүй байх тохиолдол гардаг.

Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг цагдаа болон холбогдох мэргэжилтнүүд ирэх хүртэл хүүхдийг асран хамгаалагчаас нь түр тусгаарлан шаардлагатай эмнэлгийн тусламж үзүүлдэг ба хүчирхийлэлд өртсөн хүүхдийг эмнэлэгт байх хугацаанд эрүүл мэндийн үйлчилгээг бүрэн дүүрэн хийдэг. Тухайн хүүхэд эмнэлэгт байх хугацаандаа эрүүл мэндийн болон сэтгэл зүйн тусламж үйлчилгээг бүрэн авдаг боловч эмнэлгээс гарч гэртээ болон асран хамгаалагчийн хараа хяналт, бусад байгууллагад шилжсэний дараа тухайн хүүхдийн эрүүл мэндийн болон сэтгэл зүйн үйлчилгээ тасалдаж цаашид хүүхэд ямар үйлчилгээ авдаг талаар тодорхой мэдээлэл тус

Шигтгээ 2. ЭХЭМҮТ-ийн Нийгмийн ажилтан

Эмнэлгийн тусламж үйлчилгээ авч байсан хүүхэд маань эмчилгээний явцад ирэхгүй алга болох, эмчилгээгээ тасалдуулах тохиолдол их байдаг. Эцэг, эх, асран хамгаалагч руу нь холбогдож байж заримыг нь олж авч, эмчилгээнд буцаан хамруулдаг.

эмнэлэгт ирдэггүй байна. Мөн амбулаториор эмчилгээ хийгдэх шаардлагатай буюу тодорхой хугацаанд хяналтад байх шаардлагатай үйлчлүүлэгч хүүхдүүд байдаг ч хүүхдүүд эмчилгээгээ дундаас нь орхих, давтан үзлэгтээ орохгүй байх тохиолдол гардаг. Гэтэл зарим тохиолдолд хохирогч хүүхдүүд хүчирхийлэлд өртөн дахин дахин ирэх тохиолдлууд ч байдаг бөгөөд сэтгэл зүйн хувьд маш хүнд хэлбэрт шилжсэн, амиа хорлох оролдлого хийсэн тохиолдол ч байдаг. Энэ нь анх эмнэлгийн болон бусад хэлбэрээр тусламж авсан хүүхдийн хүчирхийллийн шалтгаан нөхцөл арилаагүй, төрийн болон хүүхдийн эрхийг хамгаалах байгууллагын уялдаа холбоо муу, хүүхэд бүрэн төгс үйлчилгээ авч чадахгүй байгааг харуулж байна. Үүний зэрэгцээ мөрдөн шалгах ажиллагааны явцад хохирогч хүүхэд олдохгүй тохиолдолд мөрдөгч нар ЭХЭМҮТ-тэй холбогдож хүүхдийг олж, мэдүүлэг өгүүлэхийг шаардах ч явдал гардаг ажээ. Хүүхэд хамгааллын чиглэлээр үүрэг хүлээсэн байгууллага хоорондын ажлын уялдаа холбоогүйн улмаас хүчирхийллийн хохирогч болсон хүүхэд үйлчилгээ авч чадахгүйд хүрч эрх ашиг нь давхар хохироход хүрч байна.

Хэрэв ЭХЭМҮТ-өөс 108 утсанд өгсөн дуудлагын дагуу холбогдсон хүүхэд байвал тухайн хүүхдийн өвчний түүх ЭХЭМҮТ-д аль хэдийн үүсэж, эмчилгээгээ үргэлжлүүлэн тухайн эмнэлэгтээ хийлгэх боломжтой боловч хамтарсан баг нөхцөл байдлын үнэлгээг хийсний дараа журмын дагуу харьяа дүүргийн эмнэлэгт эмнэлгийн тусламж үзүүлэхээр хандах тохиолдол мөн гардаг ажээ. ЭХЭМҮТ-д нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх төв шиг цагдаа ажилладаггүй бөгөөд хүчирхийлэлд өртсөн хүүхдийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг хуульд зааснаар цогц байдлаар хэрэгжүүлэх үүрэг тодорхойлогдоогүй гэж үзэхээр байна.

Хэдий тийм боловч хүүхдэд үзүүлдэг тусламж үйлчилгээ нь нэг цэгийн үйлчилгээний төвтэй адил эрүүл мэндийн сэтгэл зүйн болон холбон зуучлах, түр тусгаарлан эмчлэх зэрэг хэлбэртэй байна.

Шигтгээ 3. ЭХЭМҮТ-ийн Сэтгэл зүйч

Сэтгэл зүйн зөвлөгөө өгч байх явцад ар гэрээс нь дарамт шахалт ирэх тохиолдол их байдаг. Хүүхдээ авч явна, танайхаар эмчлүүлэхгүй гэх мэт. Мөн миний ажил үүрэгт үйлчлүүлэгч хүүхдүүдтэй ажиллахаас гадна эх барих эмэгтэйчүүдийн эмнэлэгт ирсэн үйлчлүүлэгчидтэй ажиллах, мөн дотоод ажилтнууддаа сургалт хийх зэргээр ачаалал маш их байдаг. Зарим хүүхэд над дээр ирэхдээ аль хэдийн өөртөө хаалт үүсгэчихсэн байдаг. Энэ нь мөрдөн байцаалтын явцад мэдүүлэг өгөхдөө цочирдож, сандарснаас үүдэлтэй болов уу гэж ажиглагддаг.

Хүчирхийлэлд өртсөн байж болзошгүй хүүхдийн ар гэр, асран хамгаалагчийн зүгээс эмч, сэтгэл зүйчид дарамт үзүүлэх байдал их байдаг боловч эмч нарын биед халдсан тохиолдол гараагүй бөгөөд харин гарвал эмч, эмнэлгийн ажилтныг хамгаалах, хохирогчийг эмнэлэгт байх хугацаанд хамгаалах бололцоо муу байна. Учир нь тус эмнэлэгт цагдаа болон хамгаалалтын ажилтан 24 цагаар ажилладаггүй.

Хүний эрүүл мэндийн нууцыг Хувь хүний нууцын тухай хуулиар хамгаалсан байдаг. Хуулиар хамгаалагдсан нууцтай танилцах мэдээлэл авах эрх нь насанд хүрээгүй хүний хувьд асран хамгаалагч байхаас гадна зохих зөвшөөрөл бүхий хуулийн, хууль сахиулах байгууллагын ажилтнууд байдаг. Хүчирхийлэлд өртсөн хүүхдийн эрүүл мэндийн нууцыг хэрхэн хамгаалах талаар эмч, эмнэлгийн ажилтнуудаас асуухад цагдаа болон холбогдох хүүхэд хамгааллын байгууллагын ажилтнууд, асран хамгаалагчид нь мэдээлэхээс өөрөөр задруулдаггүй хэмээн хариулснаас үзэхэд нууцын тухай тодорхой ойлголттой байгааг харуулж байна. Гэсэн хэдий ч эмч нарт өвчтөний болон ар гэрийн саналыг харгалзан, зөвшөөрөл авах тохиолдол болон заавал мэдээлэх хуулийн үүргийг нууцтай нь хэрхэн холбох талаар хууль зүйн талаас ойлголт өгөх нь зүйтэй байна.

Гэвч үйлчлүүлэгч, тэдний ар гэрийн зүгээс энэ асуудал задрах вий гэсэн айдас агуулдгаас хүчирхийлэл үйлдэгчийг мэдсэн ч нуух, үл мэдээлэх байдал гаргасаар байдаг. Мөн зарим тохиолдолд өсвөр насны охид жирэмсэн болсон бэлгийн харьцаанд орсон, хүчирхийлэлд өртсөнөө эцэг эх, гэр бүлдээ хэлэхгүй байхыг эмч нараас хүсэх тохиолдол гардаг ажээ. Ийм тохиолдолд хуулийн зохицуулалт тодорхой биш байдаг талаар холбогдох хүмүүс дурдаж байсан. 16 болон түүнээс доош настай хүүхэд бэлгийн харьцаанд орсон байх нь гэмт хэргийн шинжтэй байх тул энэ тохиолдолд хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч болон холбогдох байгууллагуудад мэдэгддэг байна. Харин 16 насанд хүрсэн 18 нас хүрээгүй хүүхэд өөрийн эрүүл мэндийн байдлыг бусдад болон гэр бүлийнхэндээ мэдэгдэхийг хүсээгүй тохиолдолд эмч нар хэрхэн хандах ёстой вэ гэдэг талаар хуулийн зохицуулалт тодорхой биш байгаа тул тухайн тохиолдолд үйлчлүүлэгч хүүхэд ямар шалтгааны улмаас гэр бүлдээ мэдэгдэхийг хүсэхгүй байгааг асуумж болон нөхцөл байдлын үнэлгээг хийж тодруулдаг ажээ.

Шигтгээ 4. Лантуун дохио ТББ-ын нийгмийн ажилтан

Манай түр хамгаалах байранд ирсэн хүүхдүүдэд эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх зайлшгүй шаардлага байдаг. Бид ихэвчлэн Гэмтлийн эмнэлгийн нэг цэгийн үйлчилгээ болон ЭХЭМҮТ-ийн өсвөр үеийн поликлиник дээр хүүхдүүдээ авч очдог. Ихэнхдээ хүүхдүүд маань сэтгэл санааны цочролд орсон байдаг болохоор олон хүн дунд дараалал хүлээж суухдаа тавгүйтэж, хүмүүсээс айж бэргэсэн байдалтай байдаг. Мөн бидэнд хамгийн бэрхшээлтэй зүйл нь ерөнхий боловсролын сургуульд сурч байгаа хүүхдүүдийн маань сургууль завсардалт юм. Хүчирхийлэлд өртсөн хүүхдүүдийг суурь боловсролын үйлчилгээнд тасралтгүй хамруулах журам байдаг боловч огт хэрэгждэггүй.


Эндээс дүгнэхэд эмч, эмнэлгийн ажилтнууд зарим өсвөр насны хохирогчийн нөхцөл байдал, хүсэл зоригийг хангах үүднээс (өөрсдөө хуулийн байгууллагад хандана гэх зэрэг тохиолдолд) зарим хүчирхийллийн шинжтэй үйлдлийг цагдаагийн байгууллагад мэдээлэхгүй өнгөрөөх тохиолдол гарч

болзошгүй байна. Үүнийг хуулийн хүрээнд авч үзвэл эмч, эмнэлгийн ажилтан гэмт хэргийг үл мэдээлэх, нуун далдалж буй хэлбэр болох тул насанд хүрээгүй хүн хүчирхийлэлд өртсөн үйлдлийг хуулийн байгууллагад гарцаагүй мэдэгдэж, шалгуулдаг байх нь зүйтэй.

Хүчирхийлэлд өртсөн хүүхдийн сэтгэц, сэтгэл зүйн асуудал хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүх шатанд, мөн эмнэлгийн тусламж үйлчилгээ авах үед ч хөндөгддөг. ЭХЭМҮТ дээр ажлын бус цагаар буюу жижүүр эмчийн ээлжид ирсэн хүүхэд эмчийн үзлэг, асуумжаар хүчирхийлэлд өртсөн нь тогтоогдмогц тухайн жижүүр эмч ГБЗХГ-ын мэргэжилтэн эсхүл хүүхдийн 108 болон цагдаагийн 102 утаснуудад мэдээлэл өгдөг. ЭХЭМҮТ-д сэтгэл зүйч, нийгмийн ажилтан хонож ажилладаггүй тул тэр бүр нөхцөл байдлын үнэлгээ хийх болон хүүхдэд анхан шатны сэтгэл зүйн зөвлөмж, тусламж үзүүлэх боломжгүй ажээ.

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн мэдээлэлд хийсэн дүн шинжилгээгээр 2015-2017 онд хүчиндэх, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах, 16 насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох гэмт хэргийн насанд хүрээгүй хохирогч буюу 0-18 насны 113 хүүхдэд шүүхийн сэтгэц гэм судлалын дүгнэлт гарсан бөгөөд үүнээс 38 нь сэтгэцийн эмгэгтэй гэсэн дүгнэлт гарсан байна. Сэтгэцийн эмгэгтэй гэж оношлогдсон хохирогчийн 44.6 хувь нь оюуны хөнгөн болон хүндэвтэр хомсдолтой (34.2 хувь оюуны хөнгөн хомсдолтой, 5.2 хувь нь оюуны хүндэвтэр хомсдолтой, 5.2 хувь нь төрх үйлийн эмгэгтэй байгаа), 55.4 хувь нь сэтгэцийн хувьд гэмтлийн дараах дасан зохицохуйн хямралтай гэж оношлогдсон нь гэмт хэргийн хохирогч болсны улмаас сэтгэцийн эмгэгтэй болсон гэсэн үг юм.

График 1. Шүүхийн сэтгэц гэм судлалын дүгнэлт



Гэмтлийн дараах дасан зохицохуйн хямралтай гэж оношлогдсон хүүхдүүдэд сэтгэл заслын эмчилгээ зайлшгүй шаардлагатай ч уг

эмчилгээ нь өндөр өртөгтэй мөн түүнчлэн уг хохирлыг буруутай этгээдээр нөхөн гаргуулах боломж хомс байна.

Хоёр. ХҮҮХДИЙН БЭЛГИЙН ХАЛДАШГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ ҮЙЛДЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН ШАЛТГААН, ХЭРЭГСЭХГҮЙ БОЛГОСОН ҮНДЭСЛЭЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

2015-2017 онд дүүргийн цагдаагийн хэлтсүүд хүүхдийн бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдэгдсэн тухай гомдол, мэдээллийг хүлээн авч, мөрдөн шалгах явцдаа эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан тохиолдол байхгүй байна. Зөвхөн 1 гомдолд мөрдөгч, эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах тухай санал хүргүүлснийг прокурор эрүүгийн хэрэг үүсгэн, мөрдөн шалгуулахаар буцаажээ. Нийслэлийн хэмжээнд хүүхдийн бэлгийн халдашгүй байдлын эсрэг буюу тухайн үед үйлчилж байсан Эрүүгийн хуулийн тусгай ангийн (цаашид ЭХТА гэх) 122 (Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй хурьцал үйлдэх), 125 (Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах), 126 (Хүчиндэх) зүйл, заалтаар зүйлчлэн шалгаж, хэрэгсэхгүй болгосон нийт 39 хэрэг байна. 2015, 2016 онуудад тус бүр 18, 2017 онд 3 хэргийг хэрэгсэхгүй болгосон ба 9 хэргийн эзэн холбогдогч нь тогтоогдоогүй, 1 хэргийн эзэн холбогдогч нь тодорхой ч гадаад улсад зорчсон ба гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдоогүй гэсэн үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгожээ.

ЭХТА-ийн 122 дугаар зүйл буюу хохирогчийг 16 насанд хүрээгүйг мэдсээр байж хурьцал үйлдэх гэмт хэрэг Чингэлтэй, Сүхбаатар дүүрэгт тус бүр 1, Баянзүрх, Хан-Уул дүүрэгт

тус тус 2, нийт 6 хэрэг, ЭХТА-ийн 125 дугаар зүйл буюу бэлгийн дур хүслээ ёс бусаар хангасан гэмт хэрэг Баянзүрх, Хан-Уул дүүрэгт тус бүр 1 буюу нийслэлийн хэмжээнд нийт 2 хэрэг, ЭХТА-ийн 126 дугаар зүйлд заасан хүчиндэх гэмт хэрэг Чингэлтэй дүүрэгт 3, Хан - Уул дүүрэгт 2, Баянзүрх дүүрэгт 11, Сүхбаатар дүүрэгт 4, Сонгино хайрхан дүүрэгт 6, Баянгол дүүрэгт 5 нийт 31 гэмт хэргийг хэрэгсэхгүй болгожээ.

Хүчиндэх гэмт хэргийг хуулийн зүйлчлэлийн заалт тус бүрээр нь авч үзвэл 126.1 дэх заалтаар зүйлчлэгдсэн хэрэг Чингэлтэй, Хан-Уул дүүрэгт тус бүр 2, Баянзүрх дүүрэгт 4, Сонгино хайрхан дүүрэгт 1 нийт 9, 126.2 дахь заалтаар зүйлчлэгдсэн гэмт хэрэг Чингэлтэй дүүрэгт 1, Баянзүрх дүүрэгт 4, Сүхбаатар дүүрэгт 3, Сонгино хайрхан дүүрэгт 4, Баянгол дүүрэгт 3 нийт 15, 126.3 дахь заалтаар зүйлчлэгдсэн гэмт хэрэг Баянзүрх дүүрэгт 3, Баянгол дүүрэгт 2, Сүхбаатар, Сонгино хайрхан дүүрэгт тус бүр 1, нийт 7 хэрэг үүсгэн шалгаад, тус тус хэрэгсэхгүй болгожээ.


Гэмт хэргийн улмаас 40 хүүхэд хохирсон бөгөөд 0-13 насны 6, 14-15 насны 19, 16-18 насны 15 хүүхэд байна. Нийт хохирогчдын 64.7 хувь нь гэр хороололд, 35.3 хувь нь орон сууцны хороололд амьдардаг.

График 2. Хүүхдийн эсрэг гэм хэрэг үйлдэгдсэн газрууд, хэргийн тоо



Дээрх үзүүлэлтээс үзэхэд, хүүхдийн бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт аль ч насны хүүхэд өртөж байгаагийн зэрэгцээ, нийслэлийн захын гэр хороололд ихээр үйлдэгдэж байгааг харуулж байна. Энэ төрлийн гэмт хэрэгт өртсөн охидын 80 хувь гэр бүлийн гишүүн, танил найз, нөхдөдөө хүчиндүүлсэн нь анхаарал татаж байна. Тухайлбал, 8 охин (15 насны 5, 14 насны 2, 13 насны 1) хүчирхийлэгчтэй нийгмийн сүлжээгээр танилцсан, 3 охин (14 насны 3, 15 насны 1) олон нийтийн газарт, бусад нь ихэвчлэн найз нөхдөөрөө дамжуулан хүчирхийлэгчтэй танилцсан, эсвэл нэг хороонд амьдардаг байжээ.

График 3. Хүчирхийлэгчтэй ямар холбоотой болох



Хохирогчоор тогтоогдсон хүүхдүүдээс 12 хүүхэд (17 насны 4, 15 насны 4, 14 насны 3, 13 насны 1) өмнө нь гэмт этгээдтэй танил төдийгүй, бэлгийн харьцаатай найзууд болох нь мөрдөн шалгах ажиллагааны явцад тогтоогдсон аж.

Харин эцэг эхчүүд хүүхдээ жирэмсэлсэн, эсвэл бэлгийн харьцаанд орсон тухай мэдмэгц хохирогч өөрийгөө өмгөөлөх үүднээс ихэвчлэн танихгүй хүнд хүчиндүүлсэн гэж мэдүүлдэг байна. Дүгнэн үзвэл, өсвөр үеийн охид 13наснаас, хөвгүүд 15 наснаас бэлгийн харьцаанд орж байгааг анхаарч эцэг эх, сургуулийн эмч, багш, нийгмийн ажилтнууд бэлгийн харилцааны зөв хандлага төлөвшүүлэх талаар зөвлөмж өгч байх шаардлагатай ажээ.

Хэргийн материалаас үзэхэд, уг гэмт хэргийн талаарх мэдээллийг гол төлөв эцэг, эх, төрөл төрөгсөд нь өгдөг ч зарим тохиолдолд хохирогч, түүний ар гэрийнхэн нэр хүндээ бодох эсвэл сургуулиас хасагдаж болзошгүй

үр дагаврыг тооцох байдлаар хуулийн байгууллагад ханддаггүй, мөн хохирогчийг буруутгах олон нийтийн хандлага, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад оролцогчийн талаарх нууцлалыг хангаж чадахгүй байгаатай холбоотойгоор хуулийн байгууллагад хандах хүсэлгүй, өөр хоорондоо зохицох байдлаар хүүхдийн эрх ашгийг хохироож байна.

Бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт нийт 51 хүнийг яллагдагчаар татсанаас дагавар охиноо хүчиндсэн 2, төрсөн охиноо хүчиндсэн 2, завдсан 2 яллагдагч бэлгийн замаар дамжих халдварт өвчтэй байжээ. Мөн бүлэглэн үйлдсэн 7 хэргийн 60 хувийг ерөнхий боловсролын сургуулийн сурагчид үйлдсэн байна.

Хохирогчдын хувьд 14 насны 2, 15 насны 3, 16 насны нэг хохирогч гэмт хэргийн улмаас жирэмслэн, үр хөндүүлсэн байх ба жирэмсэлсэн болон сэтгэл зүйн хямралд орсон тохиолдолд нөхөн төлбөр гаргуулахаар нэхэмжлэл гаргаж байжээ. Судалгаанд хамрагдсан хэргээс 3 хохирогч нөхөн төлбөр авч байжээ. Тухайлбал, 201425005206 дугаартай хэрэгт 8,000,000₮, 201525011364 дугаартай хэрэгт 1,055,000₮ нэхэмжилснээс 350,000₮, 201525040399 дугаартай хэрэгт 15,000,000₮ гаргуулж авсан байна.

Хэрэг бүртгэл, мөрдөн байцаалтын явцад албан бусаар хохирогчийн хууль ёсны төлөөлөгч, яллагдагч хоорондоо тохиролцон, мөнгө хүлээлцэж дараа нь тэр тухайгаа мөрдөгчид тэмдэглүүлэх, мөнгө шилжүүлсэн баримтыг хавтаст хэрэгт хавсаргах, гомдолгүй хэмээн мэдүүлэх байдал эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгосон хавтаст хэргүүдтэй танилцах явцад ажиглагдлаа. Мөн хэрэгсэхгүй болсон хэргүүдтэй танилцах явцад хохирогчдын 25 буюу 36.7 хувь нь өөрийгөө хянах чадваргүй болтлоо согтсоноос бэлгийн хүчирхийлэлд өртсөн, ийнхүү биеэ хянах, хамгаалах чадваргүй болсон охидын 28 хувь нь 14-16, 16 хувь нь 16-18 насныхан байжээ.

Бэлгийн хүчирхийлэлд өртсөн шалтгааныг авч үзвэл оюутнууд баяр ёслол, амралтын өдрүүдэд нутаг усаараа, ангиараа нийлэн архи дан согтуурч улмаар замбараагүй бэлгийн харьцаанд ордог, ЕБС-ийн охид хөвгүүддээ таалагдахын тулд архи ууж,

бэлгийн харьцаанд ороход бэлэн байх нь элбэг байдаг бол оюутан, сурагчид нийгмийн сүлжээгээр загвар өмсөгч болгоно, кино зураг авалтад оруулна, санхүүгийн дэмжлэг үзүүлнэ гэсэн зар, цахим захианд хууртан, зальхай хүмүүсийн хэлсэн бүгдийг хийхэд бэлэн байдгаас болдог байна. Мөн зарим нь фэйсбүүк хаягтаа насаа ахиулан тавьснаас гэмт этгээд, хохирогчийн насанд хүрээгүйг мэдээгүй гэж мэдүүлэх нь цөөнгүй тохиолджээ.

Үйлчилгээний байгууллагууд 18 насанд хүрээгүй хүнд согтууруулах ундааны зүйл худалдаалах хориотой журмыг биелүүлдэггүйгээс, ялангуяа ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд согтууруулах ундааны хэрэглээ хэвшмэл шинжтэй болсон. Хэргийн материалаас үзэхэд сурагчид нийлж цугларсан үедээ өөрсдийн гар утас, эд зүйлсийг барьцаалан зээлдүүлэх газарт тавин авсан мөнгөөрөө хүртээмжтэйгээр нь том савлагаатай архи, пиво авч хэрэглэх нь түгээмэл байна.

Нийт хэргийн шийдвэрлэлтийн байдлыг тухайн үед хүчин төгөлдөр үйлчилж байсан Эрүүгийн хууль болон эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох үндэслэлээр нь авч үзвэл: Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 208 дугаар зүйлийн 208.1.1, 24 дүгээр зүйлийн

24.1.1 дэх зүйл буюу гэмт хэрэг үйлдэгдсэн нь тогтоогдоогүй болон яллагдагч эрүүгийн хариуцлага хүлээх насанд хүрээгүй, гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй үндэслэлээр нийт хэргийг шийдвэрлэсэн байна. Эрүүгийн хуулийн 77.1 буюу Өршөөл үзүүлэх тухай Монгол улсын хуулиар гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлж болох тухай заалтаар 1 хэргийг хэрэгсэхгүй болгожээ.

Хэргийн шийдвэрлэсэн байдлыг Эрүүгийн хуульд заасан зүйл, заалтаар авч үзвэл ЭХТА-ийн 122 дугаар зүйлийн 122.1. 16 насанд хүрээгүй хүнтэй хурьцал үйлдэх заалтаар 5 хэрэг, ЭХТА-ийн 125 дугаар зүйлийн 125.1 бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах заалтаар зүйлчлэгдсэн 2 хэргийг Эрүүгийн байцаан шийтгэх зүйлийн 208.1.1.1, 24.1.1-д заасан үндэслэлээр тус тус хэрэгсэхгүй болгосон байна. ЭХТА-ийн 126 буюу хүчиндэх зүйлээр зүйлчлэгдсэн 31 хэргийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 208.1.3, 25 дугаар зүйлийн 25.1-д заасан үндэслэлээр 3 хэрэг, үлдсэн хэргийг 208.1.1.1, 24.1.1-д заасан үндэслэлээр тус тус хэрэгсэхгүй болгожээ. Мөн хэргийг шалгах явцад 2 яллагдагчид урьд сонгосон ЭХТА-ийн 126 дугаар зүйлд заасан ялын тогтоолыг хүчингүй болгож шинээр ЭХТА-ийн 122 дугаар зүйлд заасан ялыг сонгосон байна.

ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

- ЭХЭМҮТ нь хүүхдийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг аливаа үйлдлийг илрүүлэн мэдээлэх хуулиар олгогдсон чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаж байна. Гэвч тус эмнэлгийн эмч ажилтнуудыг хүчирхийллийг илрүүлэх мэдээлэх талаар үйл ажиллагааг улам сайжруулах, ялангуяа хүчирхийллийг илрүүлэх чиглэлд илүү анхаарч чадваржуулах шаардлагатай байна.
- ЭХЭМҮТ нь хүчирхийлэлд өртсөн хүүхдийг илрүүлэх, гэмт хэргийн гомдол мэдээллийг цагдаагийн байгууллагад мэдэгдэх үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр холбогдох журмыг боловсруулах нь зүйтэй. Үүнд:
 - Хүүхдэд үзлэг хийх явцад хүчирхийлэлд өртсөн байж болзошгүй шинж тэмдэг

ажиглагдахад асуумжийг нарийвчилж тэмдэглэл үйлдэх, хүчирхийлэлд өртсөн байж болзошгүй тохиолдолд эмч хүүхдэд шаардлагатай тусламж үйлчилгээг тогтсон дарааллын дагуу үзүүлэх, холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдээлэх зэрэг процессыг тусгасан тусгай удирдамж баталж мөрдүүлэх.

- Өвчтөний нэгдсэн мэдээллийн санг сайжруулах. Өмнө нь хүчирхийлэлд өртсөн болох нь тогтоогдож эмчилгээ хийлгэж байсан хүүхэд дахин ижил шинж тэмдэг, зовууртайгаар эмнэлгийн тусламж авахаар ирэх тохиолдолд эмч нар нарийвчилсан үзлэг хийх замаар хүүхэд хүчирхийлэлд дахин давтан өртөж байгааг илрүүлэх шаардлагатай.

- Хүчирхийлэлд өртсөн хүүхдэд илрэх зан төлөвийн онцлог, бие махбодод илрэх шинж тэмдэг, сэжиглэх үндэслэлүүд, өвчтөнтэй харьцах, асуумж авах, хууль эрх зүйн хүрээнд зайлшгүй хийх, авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар эмч, эмнэлгийн ажилтнуудад мэргэжлийн сургалт явуулах.
- Хууль эрх зүйн хүрээнд хувь хүний нууцыг хамгаалах, эмнэлгийн шаардлагатай ажилбарын зөвшөөрөл авахад асран хамгаалагчийн зөвшөөрөл шаардлагатай үед хэрвээ асран хамгаалагч нь хүчирхийлэгч байж болзошгүй, ажилбар хийхээс татгалзаж байгаа нь хүүхдийн эрх ашиг сонирхолд нийцэхгүй байвал авах арга хэмжээний талаар холбогдох хуульд нийцсэн заавар удирдамжтай болох.
- Мөн хүчирхийлэлд өртсөн хүүхэдтэй анхны үзлэгээс эхлээд сэтгэл зүйчийн тусламжийг цаг алдалгүй үзүүлэх, сэтгэл зүйчийг ээлжээр ажиллуулдаг болгох учир нь ажлын бус цагаар хүчирхийлэлд өртсөн хүүхэд ирэхэд сэтгэл зүйчийн тусламж авч чаддаггүй байна.
- Эмнэлэгт цагдаагийн ажилтан хохирогч хүүхдээс анхны мэдээлэл, мэдүүлэг авах тохиолдолд сэтгэл зүйч эмчийг хамт байлгах.
- Судалгааны хүрээнд ЭХЭМҮТ, НЦГ, ГБЗХГ-аас хүчирхийлэлд өртсөн хүүхдийн талаар гомдол мэдээллийн тоо баримтыг авахад төрийн байгууллагуудын тоо хоорондоо зөрүүтэй, НЦГ-аас гомдол мэдээллийг хүлээн авахдаа дуудлага өгсөн газраар биш, хохирогчийн овог нэрээр бүртгэж авдаг зэргээс шалтгаалан бүртгэлүүд зөрөх тохиолдол байна. Тухайлбал, НЦГ-т ЭХЭМҮТ-ээс мэдээлсэн тоо баримтын бүртгэл гарах боломжгүйгээс ЭХЭМҮТ-д илрүүлсэн хүүхдийн эсрэг хүчирхийллийн гэмт хэргийн шийдвэрлэлт хэрхсэнийг мэдэх боломж хязгаарлагдаж байна. Тиймээс НЦГ бүртгэлдээ дуудлага мэдээлэл өгсөн газрыг нэмж тусгавал мэдээллийн зөрүү арилж, энэ асуудалд хөндлөнгийн мониторинг хийх боломж бүрдэнэ.
- Судалгааны явцад ГБЗХГ-ын харьяа хүүхдийн 108 утасны дэргэдэх түр хамгаалах байрны үйл ажиллагаа, орчин нөхцөлтэй холбоотойгоор хүүхэд хохирсон тохиолдол гарсан тухай мэдээлэл авсан бөгөөд цаашид түр хамгаалах байрны стандарт, үйлчилгээ, нөхцөл байдлын талаар судалж, сайжруулах арга хэмжээ авах шаардлагатай.
- Хүчирхийлэлд өртсөн хүүхэд цагдаад мэдүүлэг тайлбар өгөх зэргээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох үед сэтгэл зүйн байдал эрс мууддаг, айж сүрддэг, болсон явдлыг эсрэгээр ярих, эсхүл огт ярихаа болих зэрэг тохиолдол нэлээдгүй гардаг бөгөөд мэдүүлэг авч буй цагдаагийн арга барил, зан авир хандлагатай шууд холбоотой байдаг байна. Хүчирхийлэлд өртсөн охидоос эрэгтэй мөрдөгч мэдүүлэг авах, харилцах, хэргийн талаар яриулах зэрэг нь хохирогчийн сэтгэл зүйд сөргөөр нөлөөлж байгааг сэтгэл зүйч эмч ярьж байна. Иймд цагдаагийн ажилтнуудын ур чадварыг сайжруулах хохирогчтой харилцах арга барилд сургаж дадлагажуулах шаардлагатай байна.
- Хүчирхийлэлд өртсөн хүүхдүүд хүүхэд хамгааллын бүрэн төгс үйлчилгээ авч чадахгүй тохиолдлууд байсаар байгаа бөгөөд төрийн байгууллага хооронд хүүхдийн үйлчилгээ орхигдох, эмчилгээ үйлчилгээ дундаасаа тасалдах тохиолдлууд гарсаар байна. Тухайлбал, ЭХЭМҮТ-д эмнэлгийн тусламж авч эмчлэгдээд, ӨҮК-т сэтгэл заслын урт хугацааны үйлчилгээнд хамрагдах шаардлагатай хүүхэд өөр байгууллагад шилжсэнээр эмчилгээ нь тасардаг. Гэтэл тухайн хүүхэд шаардлагатай сэтгэл зүйн үйлчилгээ аваагүйгээс гадна дахин хүчирхийлэлд өртсөн тохиолдол гардаг ажээ. Үүнийг зохих газрууд сайтар анхаарч хохирогч хүүхдэд иж бүрэн үйлчилгээ үзүүлдэг тогтолцоотой болох шаардлагатай.

НОМ ЗҮЙ

Хууль эрх зүйн акт

1. Хүүхэд хамгааллын тухай хууль, 2016 он
2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 2016 он
3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2017 он
4. Зөрчлийн тухай хууль, 2017 он
5. Гэрч хохирогчийг хамгаалах тухай хууль, 2013 он
6. Эрүүл мэндийн тухай хууль, 2011 он
7. Хувь хүний нууцын тухай хууль, 2005 он
8. Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг түр хамгаалах журам, ХЗДХС, 2017 оны А/39

9. Нөхцөл байдлын үнэлгээ хийх журам, ХНХС, ХЗДХС, 2017 оны А/1201, А/178
10. Түр хамгаалан байрлуулах үйлчилгээний зардлыг нэг хүнд ногдох хувьсах зардлын хэмжээгээр тооцох бөгөөд хувьсах зардлыг тооцох журам, ХНХС
11. Түр хамгаалах байрны үйлчилгээ үзүүлэх журам, ХНХС
12. Түр хамгаалах байрны стандарт, Стандартчилал техникийн зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага
13. Нэг цэгийн үйлчилгээний төвийн аюулгүй байдалд хяналт тавих журам, ХЗДХС, 2017 оны А/38
14. Нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх, санхүүжүүлэх журам, ХЗДХС, ЭМС, ХНХС, 2017 оны А/80, А/132, А/60
15. Нэг цэгийн үйлчилгээний төвийн стандарт, Стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага
16. Хохирогчид эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх журам, ЭМС, 2017 оны А/394
17. Хохирогчид сэтгэл зүйн зөвлөгөө үзүүлэх журам, ХНХС, 2017 оны А/74
18. Хохирогчид сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх журам, ЭМС, 2017 оны А/394
19. Холбон зуучлах үйлчилгээний журам, ХНХС, 2017 оны А/73
20. Зан үйлд нөлөөлөх албадан сургалт зохион байгуулах журам, ХЗДХС, ХНХС, 2009 оны А/69, А/55
21. Зан үйлд нөлөөлөх сайн дурын сургалтын журам, ХЗДХС, ХНХС, ЭМС, 2009 оны А/63, А/48, А/106
22. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үйлчилгээ үзүүлэх журам, ХНХС, 2017 оны А/33
23. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх журам, ХЗДХС, 2017 оны А/29
24. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд эмнэлгийн болон сэтгэл зүй, сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх журам, ЭМС, 2017 оны А/394
25. Гэр бүлийн хүчирхийллийн талаарх статистик мэдээлэл, тоо бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлэх журам, ХЗДХС, 2017 оны А/25
26. Хохирогчийг хүчирхийлэл үйлдэгчтэй уулзуулах журам, ХЗДХС, ХНХС, 2017 оны А/56, А/35
27. Хууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлэх болон холбогдох бусад байгууллага хоорондын мэдээлэл солилцох журам, ХЗДХС, 2017 оны А/25
28. Хамтарсан багийн ажиллах журам, ХНХС, 2016 оны А/328

Бусад эх сурвалж:

1. Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, НҮБ, 2011 он
2. Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Өсвөр үеийн клиникийн 2018 оны үйл ажиллагааны тайлан, УБ, 2019 он
3. "Хүчирхийллийн нүцгэн үнэн" жендерт суурилсан хүчирхийллийн судалгааны тайлан, УБ, 2018 он
4. "Гэр бүлийн хүчирхийлэлд өртөгсдөд тусламж үзүүлэх эмнэлэгт түшиглэсэн "Нэг цэгийн үйлчилгээний төв"-тэй холбоотой бодлогын баримт бичгийн нөхцөл байдлын үнэлгээ", Эрүүл мэндийн яам, Нийгмийн эрүүл мэндийн шинэчлэлийн хүрээлэн, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, UNFPA УБ, 2019 он
5. "Хүчирхийлэлд өртсөн болон эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд ба эмэгтэйчүүдэд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх журам", ЭХЭМҮТ, УБ, 2019 он
6. "Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвөөр үйлчлүүлж буй хүчирхийлэлд өртсөн болон эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн нийгмийн ажлын үйлчилгээний журам", ЭХЭМҮТ, УБ, 2019 он
7. "Амиа хорлох оролдлого хийж ЭХЭМҮТ -д хүргэгдэн ирсэн өсвөр насны хүүхдэд үзүүлэх сэтгэл зүйн тусламж үйлчилгээний удирдамж", ЭХЭМҮТ, УБ, 2019 он
8. "Хүүхдийн бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, шалтгаан, нөлөөлж буй хүчин зүйлс", Хүйсийн тэгш эрхийн төв, ХСИС, Монголын эмэгтэйчүүдийн сан, судалгааны тайлан, УБ, 2019 он
9. "Хүчирхийллийн нөлөөгөөр охид эмэгтэйчүүдийн БЗДХ, ХДХВ-ийн халдварт өртөлтийн байдлыг үнэлэх" судалгааны тайлан, Хүйсийн тэгш эрхийн төв, Эрүүл мэндийн яам, УБ, 2018 он
10. World report on violence and health, WHO, 2002
11. National Research Council, 1993, Understanding Child Abuse and Neglect, Washington, DC: The National Academies Press, <https://doi.org/10.17226/2117>
12. <https://www.gov.scot/binaries/content/documents/govscot/publications/advice-and-guidance/2012/12/national-guidance-child-protection-scotland-guidance-health-professionals-scotland/documents/00411543-pdf/00411543-pdf>